

ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ,  
АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

# “ШИХИХУТУГ”

1/2002

*“ШИХИХУТУГ” ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ БАЙГУУЛАГДСАНЫ  
10 ЖИЛИЙН ОЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ЗОРИУЛАВ.*

**ШИХИХУТУГ**  
**ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ,**  
**АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ**

Дорно дэх жилдээ  
1/2002

“ШИХИХУТУГ” ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ  
БАЙГУУЛАГДСАНЫ 10 ЖИЛИЙН ОЙН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ЗОРИУЛАВ.

**АГУУЛГА**

1. *“Шихихутуг” Хууль Зүйн Дээд Сургуулийн Захирал Д.Оюунцэцэг*  
“Шихихутуг” Хууль зүйн дээд сургууль: оноо, ирээдүй (хуудас: 3-9)
2. *Доктор (Sc), профессор Ж.Болдбаатар*  
Шихихутуг бол Монголын төр, хууль цаазны үлэмж гарамгай зүтгэлтэн мөн. (хуудас: 10-13)
3. *Доктор (Sc), профессор О.Амархүү*  
Монголд хуульч үндэсний мэргэжилтэн бэлтгэсэн түүхэн асуудал (хуудас: 14-18)
4. *Доктор (Ph), профессор Б.Тува*  
Дээд боловсрол XXI зуунд (хуудас: 19-21)
5. *“Шихихутуг” Хууль Зүйн Дээд Сургуулийн Сургалтын албаны дарга Г.Улаамбаяр*  
Галиад хэлний сургалтын онол практикийн асуудлууд (хуудас: 22-24)
6. *“Шихихутуг” шүлэг*  
*Яруу найрагч Ц.Чимсүндорж* (хуудас: 25-26)

## **"Шинихутуг" Хууль зүйн дээд сургууль: өнөө, ирээдүй**

*Натсгач: "Шинихутуг" ХЗДС-ийн захирал Д.Оюунцэцэгхууль  
зүйн магистр, боловсролын менежер  
Боловсролын тэргүүний ажилтан*

*Олноо хүндэтгэсэн профессор, эрдэмтэн баян нараа!  
Оюутан залуус, төгсөгчид өө!  
Эрхэм хүндэт зочид гийчдээ!*

Монголын төр, хууль цаазны үлэмж гарамгай зүтгэлтэн Шинихутугийн нэрийг уламжлан овогдосон манай сургууль 10 жилийн тэртээ тулгын чулуугаа тавьж эрдэмийн үүдээ нээсэн билээ.

"Шинихутуг" сургуулийн энэхүү тэмдэглэлт өдрийг тохиолдуулан, номын өгөөж бүхийг харамгүй хайрлагч эрдэм суут багш нар, суралцах ая тохь тухыг илбэн тохинуулагч хичээнгүй нягт ажигтнууд, төрөлх сургуулийнхаа нэр, алдрыг ямагт эрхэмлэж, сургуулиа дуурсгаж яваа төгсөгчид, цаг мөч тутам танин мэдэхүйн баяслыг эдлэн бисалгагч оюутан залуус, бидэнд гар сунган дэмжлэг туслалааа үзүүлж энд хуран цугларсан хүндэт зочид Та бүхэнд лагшин тунгалаг, бие цэги, оюун тол, бодол нягт байхын өлзий дэмбэрэлт ерөөлийг өргөн дэвшүүлэе.

Арван жил түүхэн үйл явдал, эргэх он цаг, нэгэн байгууллагын хөгжлийн хувьд ахархан хугацаа мэт санагдавч, хорвоод мэндэлсэнээсээ хойш тоотой арван жилийг эзэдэг эрдэмт хүмүүний амьдрал оршихуйн тухайд толорхой орон зай эзлэх чамгүй хугацаа юм. Ухаарахад улиран одсон энэ арван жил бол хүн төрөлхтний болон Монгол орны хувьд шинэийг мэдрүүлж, гүн ул мөр, өнгө төрхөө үлдээсэн он жилүүд байлаа. Тухайлахад:

- Хүмүүн төрөлхтөн үндэсний хүрээнд хувиа бодож, довоо шарвуулахаасаа нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэх болсон;
- Монгол орон зах зээл, эрчимлэлийн тогтолцоонд эргэлт буцалтгүй шилжсэн;
- Ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталж, өмчийн бүх төрөл, хэлбэрийг зөвшөөрсөн гээд авийг эс тоочих билээ.

Үүний нэг үр шим нь Монгол улсад хувийн хэвшлийн их дээд сургууль үүсэн хөгжсөн явдал юм.

Шинэ зуун, шинэ мянганыг хаягдсан ер бусын түүхт үйл явдлаар баян 10 жил байлаа.

Юм бүхэнд шинэ амьдрал мэдрүүлсэн 1990-ээд оны эхээр бидний хэдэн нөхөд айсуу шагийн өнгө төрхийг танин тунгаасны үндсэн дээр өөрчлөлт шинэчлэлийг шинэ шагийн боловсрол шийдвэртэнэ гэдгийг огоорон ухаарч, тус сургуулийг байгуулах ажлыг үүсгэн санаачилж, Монгол улсын шинжлэх ухаан, боловсролын /хуучин нэрээр/ сайдын

сургалт-судалгааны нэг томоохон төв болон өсч өндийлөө. Энэ бүхнээс 2001 оны 10 дугаар сара Дээд Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн шийдвэрээр магадлан итгэмжлэгдсэн, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн "Хэрэглэгчдийг хаанд өргөмжлсөн байгууллага" шагнал хүртээнийг онцлон тэмдэглэж байна.

"Шинэхутуг" ХЗДС бол хууль зүйн дээд боловсрол эзэмшүүлэх дээд боловсролын байгууллагын статустай, хувийн хэвцлийн анхны хууль зүйн дээд сургууль юм. Тус сургууль энэ хичээлийн жилийг оролцуулаад нийт 10 удаа элсэлт авч, өдрийн ангийн 6 дахь, эчнээ ангийн 3 дахь төгсөлт хийгээд байна.

Манай сургууль 10-хан жилийн дотор ийм тодорхой амжилтанд хүрсэн нь сургалтын бүхий л үйл явцад "баги-шавь-ном" гурмыг шүтэн барилдуулаж; ямагт шинжлэх ухааны шим, утгын гүн рүү тэмүүлэх сэтгэлгээг урьдал болгож байсны ач, үр өгөөж юм.

Сургуулийнхаа замналыг дараах байдлаар хураангуйлан дүгнэж болох юм. Үүнд:

- Эрдэм номын их өргөө-их, дээд сургуулийн тулгуур хүч, шинжлэх ухаанд урмалан дуудагч, түүхчлэн хөтөлгөч нь багш нар мөн. Тус сургууль анхны хичээлийн жилд орон тооны ганц нэгхэн багштай, цагийн багш нарын хүчинд тулгуурлан хичээлээ эхэлсэн бол өдгөө эрх зүй болон ерөнхий эрдмийн хоёр тэнхимтэй, орон тооны 15 багштайн дотор шинжлэх ухааны доктор 4, дэд доктор 2, магистр 9 ажиглаж байна. Тус сургуулийн багшлах бүрэлдэхүүний нэг гол онцлог бол бүр эхнээсээ манай улсын нэртэй эрдэмтэд, улс төрчид, хуульчид орон тоогоор болон цагаар багшиж ирсэн явдал юм. Тухайлбал, Монгол улсын үндсэн хуулийн Цэврийн анхны дарга Монгол улсын гавьяат хуульч, шинжлэх ухааны доктор, профессор Г.Соод, УИХ-ын гишүүн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан, Үндсэн хуулийн Цэврийн гишүүн асан, доктор /Ph/, профессор Ч.Энхбантар, УИХ-ын гишүүн асан, академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, С.Нарангэрэл, УИХ-ын дэд дарга, дэд профессор Ж.Бямбадорж, УИХ-ын гишүүн, доктор /Ph/, профессор С.Төмөр, УИХ-ын гишүүн Р.Содхуу, УИХ-ын гишүүн асан, Үндсэн хуулийн Цэврийн гишүүн, түүхийн ухааны доктор, профессор Ж.Болдбаатар, Үндсэн хуулийн Цэврийн гишүүн асан, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Л.Бавсан, Үндсэн хуулийн Цэврийн гишүүн асан, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан, доктор, профессор О.Амархүү, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, доктор /Ph/, профессор А.Цагжид, Төрийн хэвлэл шалгах хорооны дарга Л.Жавзмаа, МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн тэнхимийн эрхлэгч, доктор /Ph/, профессор Т.Мөнхжаргал, доктор /Ph/, дэд профессор С.Цэдэндамба, доктор /Ph/, дэд профессор Д.Тамжидмаа, доктор /Ph/, дэд профессор Н.Орёл нарын зэрэг хүмүүсийг нэрлэхэд иэн таатай байна.

Манай сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд бүр эхнээс нь хичээнгүйлэн зүтгэж байсан доктор /Ph/, профессор У.Чимид, Б.Шарангомбуу, доктор Б.Түмэн, УИХ-ын гишүүн асан Г.Ганболд, ахмад дипломатч О.Хосбаяр нар ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн хэдий ч хамтран

зүтгэгчид, тэдний олон зуун шавь нар баярын энэ өдөр зүй ёсоор хүндэтгэн дурсаж байна.

Манай багш нар сургалтад орно, дорны өндөр хөгжилтэй орнуудын дэвшилтэт аргыг нэвтрүүлдэхийн зэрэгцээ сурах бичиг, гарын авлага, сургалтын кино бүтээн туурвиж, сургалтад хэрэглэж байна. Тухайлбал Д.Лундээжанцан, Ч.Энхбаатар нарын "Монгол улсын Үндсэн хуулийн эрх зүй", Ж.Болдбаатар, Д.Лундээжанцан нарын "Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал", Д.Лундээжанцан, Н.Жалбажав, Д.Отгонтуяа нарын "Эрх зүйн философи" сурах бичиг, Н.Ордын "Шүүхийн сэтгэл, эмгэг судлал", Ц.Цэвэсгийн "Эрүүгийн эрх зүйн хичээлийн бодлого, тестийн хураамж", Б.Сүрэнхүүгийн "Монгол улсын анхны иргэний хууль" гарын авлага, номыг нэрлэж болох юм. Мөн профессор Ж.Болдбаатар "Монгол улсын Засгийн газрын тэргүүн" цуврал баримтат кино хийж төр, хууль цаазын түүхийн хичээлд ашиглаж байна.

Хууль зүйн мэргэжлийн онол, арга зүйн нэг индэр болсон Шиххутуг сэтгүүлийг манай профессор багш нар эрхсэн улирал тутам гаргаж, мэргэжлийн хүрээнд олны хүртээл болж байна.

Үүсэн тогтонсон 10 жилийн дотор өөрийн гэсэн сурах бичиг, гарын авлагатай болж, залуу багш нар бие дааж ном зохиол туурвиж, эрдэм шинжилгээний илтгэл, огуудал олноор бичиж нийтлүүлдэг байгаа нь багш нарын бүрэлдэхүүн эрдэмжлэх, онол арга зүй, сэтгэлгээний шар далайшын хувьд өсч дэвжиж байгаагийн том үзүүлэлт юм. Өнгөрсөн хугацаанд тус сургуулийг үүсгэн байгуулагч Д.Лундээжанцан, тэмхэмийн эрдэмч О.Амархүү нар хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж, мөн удахгүй манай сургуулийн үүсгэн байгуулагчдын нэг Ч.Энхбаатар Унгар улсад докторын зэрэг хамгаалахаар эхэж байна. Түүнээс гадна тус сургуулийн багш нар төрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйлсэд идэвхитэй оролцож хувь хандиваа оруулж байна.

Эрдэмт багшид насан ашид шүтэж эрдэм авчлаа гарна. Билгийн чинд хүрэхэд ухаант багш хэмээх сайн газарчгүйгээр үл хүрэнэ. Энэ мэргээн сургаалаар тус сургууль багш нараа улам бүр эрдэмжүүлэх талаар цаашид бололцоотой бүхий л арга хэмжээг хэрэгжүүлэх болно.

Тус сургуулийн сургалтын гол хараа тунг нь номын далайд цаг хором тутам танин мэдэхүйн баясныг амсан эрдэм оюунд дичээнгүйлэн суралцагч оюутан залуус маань юм.

Эдүгээ манай сургуульд 330 гаруй оюутан суралцаж байгаа бөгөөд цаашид оюутны тоо нэмэгдэх төлөв хандлагатай байна. Нэг дараанд оюутан жилд дунджаар 30-34 багц цагийн хичээл үзэж, үндсэн ангийн оюутан суралцах нийт хугацаандаа 135.5 багц цаг, эцнээ анхид 101 багц цагийг тус тус цуглуулж, дээд боловсролтой, "эрх зүйч" мэргэжилтэй, бакалаврын зэрэгтэй хуульч болон бэлтгэгдэж байна. Сургууль байгуулагдсан үеэсээ өнөөг хүртэл 255 бакалаврын зэрэгтэй эрх зүйчдийг бэлтгэн гаргасны 90 хувь нь ажлын байртай, түүний 70 хувь нь

мэргэжлээрээ хууль хяналтын байгууллагад ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд 15 хүн магистрын зэрэг амжилттай хамгаалж, одоо 3 хүн докторантурт, 17 хүн магистрантурт суралцаж байгаа нь төгсөгчдийн чанарын үзүүлэлт юм.

Мөн төгсөгчдөөс 19 хүн Монгол улсын аль нэгэн их, дээд сургуульд багшилж байгаагаас 6 нь өөрийнхөө сургуульд багшаар ажиллаж байна.

Манай оюутнууд сургуулийнхаа чанар чансаа, онго төрхийг тодорхойлогч гол нүүр царай болж байна. Энэ нь холбогдох дээд байгууллагаас ажил, амжилтаар нь шалгаруулахад тэргүүн байрууд орж байсан, боловсролын хяналтын байгууллага оюутнуудаас нийгмийн мэдлэгээр шалгалт авахад эхний байранд шалгарч байсан, хууль, хяналтын байгууллагын ажилтнуудын аттестатчилалд тус сургуулийг төгсөгчид манлайлж талархал хүлээж байсныг цохон тэмдэглэж байна. Түүнчлэн манай оюутнуудын мэдлэг чадварыг юу ч үгүйсгэн, олон түмэн хэрхэн үнэлж буйг дурдахгүй байж болохгүй юм. Тус сургуульд Монголын залуучуудын холбооны "Хөдөлмөрийн алдар", "Тэргүүний залуу" алтан мөдальтай оюутан 4 байна. Мөн хууль зүйн сургалттай их, дээд сургуулиудын дунд зохиодог онол, эрдэм шинжилгээний хурал, уралдаан тэмцээнд манай сургуулийн оюутнууд удаа дараа эхний байруудад шалгарч ирвэ. Тухайлбал, их дээд сургуулиудын оюутны эрдэм шинжилгээний хуралд 6 оюутан эхний байранд шалгарч, тус сургууль 1997 онд анхны хувийн дээд сургуулиудын дунд зохиогдсон "Манайхан" тэмцээнд тэргүүн байр, 1998 онд "Залуу удирдагч" сангаас хуульч оюутан залуучуудын дунд зохиосон "New lawyers" /"Шинэ хуульчид"/ онолын тэмцээнд дэд байр, 2000, 2001 онд Худалдаа аж үйлдвэрийн танхимгаас зохиосон "Гадаад худалдааны арбитраж хэн сайн мэдэх вэ?" тэмцээнд тэргүүн байр, 2000 онд ХЗДХЯ, Ханс-зайделийн сан, "Монгол телевизээс хамтран зохион байгуулсан "Дэвжээ" тэмцээний ш тарагын тоглолтод дэд байр эзэлсэн зэргийг нэрлэхэд хангалттай юм. Түүнчлэн их, дээд сургуулиудын хооронд зохиогдсон урлаг, спортын уралдаан, тэмцээнд олон оюутан тэргүүн байруудад шалгарч байна.

Сургуулийн оюутан, профессор багш нар бүх нийтийн хууль зүйн боловсролыг дээшлүүлэх эрх зүйн сурталчилгаа явуулахад идэвхтэй оролцож ирлээ. Тухайлбал ХБНГУ-ын техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Эдийн засаг, эрх зүйн шалтгал" төслийн хүрээнд ХЗДХЯ, Монгол телевизтэй хамтарсан хууль сурталчлах "Хуулийн шаг", MN-25 сувга телевизийн "Дэнс" нэвтрүүлгүүдэд зохиомж бэлтгэн 60 гаруй удаа оролцож, үзэгчдээс өндөр үнэлэлт авсан байна. Мөн МННХ /Сорос сан/-ийн тусламжтайгаар 2000 оноос Клиник сургалтын зохион байгуулж, ахлах ангийн оюутнууд, зарим багш нар оролцож, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлөл хийх ажлыг үнэ төлбөргүй хийж байгаа нь олон түмний зүй ёсны талархлыг хүлээсээр байна. Энэ бүхэн нь оюутнууд танхимд үзсэн онолын мэдлэгээ амьдрал практик дээр баталгаад нэрлэсэн тус дөхөм үзүүлж байна. Гэхдээ манай бүх оюутан сурч мэдэхийн төлөө шаг залуу хөдөлмөрлөж байна гэж бүхэлд нь үнэлж дүгнэж харахад болохгүй нь мэдээж юм. Иймд шаг зан бол оюуны хөдөлмөрийн хүнд

хамгийн том хөрөнгө оруулалт гэдгийг залуу хүн бүр ухааран ойлгож, залуу залуагийнг эгнээгт даан тэгшлэгч номтой урагшлах цаг мөч бүрийг ноёрхолх хэрэгтэй байна.

Тус сургууль материаллаг баазын хувьд улам бүр бэхжсээр байна.

Анх Техеникийн их сургуулийн ганц нэг анги тэнхимыг түрээслэн хичээлээ эхэлж байсан бол одоо нэг ээлжинд 350 оюутан суралцах хичээлийн байртай, 9000 гаруй ном, сурах бичиг, нэг ээлжинд 34 оюутанд үйлчлэх уншлагын тэнхим бүхий номын сан, 20 оюутан зэрэг ажиллах Reading III маркийн, интернетэд холбогдсон мэдээллийн төв, практикийн хичээл явуулах клиник сургалтын төв, шүүх хуралдааны тэнхим, орос, англи хэлний болон криминалистикийн кабинет зэрэг сургалтын орчин үеийн материаллаг баазтай "айлын дайтай айл", аль ч сургуультай хэрэгцээхүйц түвшинд хүрсэн байна. Энэ бүх материаллаг баазын дотроос нэн эрхэм нь номын сан билээ. Бид номын сангаа хүн төрөлхтний эрдэм мэдлэгийн дээжсээр байжуулж, оюутан залууст хүртээхдээ их эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн:

"Номын утга нь тэнгэр мэт агуу  
дэлхий мэт өргөн, далай мэт гүн.

Номыг унших нь тэнгэрт ниссэж

дэлхийг тойрч, далайд шумбах мэт"

гэсэн үгийн гүн утгыг улам илүү сайтар мэдэрч, төрөл бүрийн ном мэдээллэл, орчин цагийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахыг ямагт эрихлэх болно. Бид ойран үед хичээлийн шигэ байр барихаар төлөвлөж байна.

Өнгөрсөн хугацаанд тус сургууль дотооддоо төдийгүй хэлийн чанадад танил болж, ХБНГУ-ын Боины их сургууль, Макс Планкийн институт, БНУУ-ын Будапештийн их сургууль, Будапешт хотноо байрлах Төв Европын их сургуулийн хуулийн салбар, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Хох хотын их сургуультай тус тус холбоо тогтоож, хамтран ажиллаж байна. Эдгээр сургуулиудтай тогтоосон хамтын ажиллагаа нь удирдах ажиглан, багш нар харилцан айлчлах, туршлага солилцох, багш нарын мэргэжлээ дээшлүүлэх, хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх, бакалаврын дараагийн шатны сургалт зохион байгуулах, ном, сурах бичиг харилцан солилцох, өндөр мэргэжлийн багш солилцох, хичээл заах зэрэг чиглэлээр явагдаж байна.

Цаашид үүгээр хязгаарлахгүй бусад орны сургуулиудтай холбоо тогтоох, хамтын ажиллагааны хэлбэрүүдийг өргөтгөх, үр өгөөжийг дээшлүүлэх талаар санаа тавин ажиллах болно.

Дээр өгүүлсэнээс үндэслэн, тус сургуулийн өвөрмөц онцлог, зарим дагуу талыг нэгтгэн дүгнэвэл:

Хувийн хэвцлийн их, дээд сургуулиар өнөөгийн шаардлагыг хангахуйц хуульч мэргэжлийн боловсон хүчин чанартай бэлтгэж болохыг сургалт, үйл ажиллагаагаараа харуулж чадсан.

Цөөн тооны оюутан элсүүлж, өндөр шаардлага, хяналт тавихын хамт тэднийг бие даах чадвар, авьяас билгийг чөлөөтэй хөгжүүлэх чиг баримталсан.

Өндөр мэргэжил, бүтээлч чадвар, шинэлэг сэтгэлгээтэй эрдэмтэн мэргэжилтнүүдээр багшлах бүрэлдэхүүнийг байнга сэлбэсэн.

Гол гол мэргэжлийн хичээлээр өөрийн гэсэн сурах бичиг, гарын аалагатай болж, улам улам боловсронгуй болгож буй.

Хууль зүйн шинжлэх ухааныг эдийн засаг, гадаад хэлний мэдлэгтэй хослон эзэмшсэн хуульчийг зах зээлийн нөхцөлд хөрөөх чадвартайгаар бэлтгэдэг.

Гадаадын аль нэг орны сургуультай хамтарсан болон олон улсын сургалтын төслүүдэд өргөнөөр оролцсон эдгээрийг дурдан тэмдэглэж байна.

XXI зууны гараанаас ирээдүйгээ өдрөгөөр тосголохыг энэ зуун шинжлэх ухаан, технологи, мэдээллийн зуун, даяаршлын зуун болох нь тодорхой байна. Шинэ зуунд бидний Монголчууд хүргүүлэх, иргэний, ардчилсан нийгмийг төлөвшүүлэх болно. Шинэ зуун, шинэ нийгэмд манай сургууль өндөр мэргэжилтэй, гадаад хэлний мэдлэг, компьютерийн боловсрол, мэдээллээ ашиглах чадвартайгаас гадна ахар богино хугацаанд зөв шийдэл гаргах, өрсөлдөгчтэйгээ ч ухаалаг хамтран ажиллах, бусад үйлэстний соёл, заншлыг ойлгон хүлээцтэй, асар их хурдантай өөрчлөгдөж буй нийгмийн шинэ нөхцөлд дасан зохицох шилдэг чадваруудыг эзэмшсэн хуульч мэргэжилтэн бэлтгэхийг эрхэмлэн зорилго болгож байна. Энэхүү эрхэм зорилгыг энд хуран цугларсан Та бүхний хамтын хүч, хөдөлмөр, хичээл зүтгэлээр шийлвэрлэнэ гэдэгтээ гүн итгэлтэй байна.

Өнгөрсөн 10 жилд сургалтын ажлын дутууг гүйцээж, дуцдыг дүүргэхийн төлөө хичээнгүйтэн зүтгэж, ухаан бодлоо харамгүй хүртээж ирсэн эрдэмтэн багш нар Та бүхэндээ талархал илэрхийлж байна.

Бидэнтэй хамтран ажиллаж тус дэмжлэг үзүүлж ирсэн УИХ-ын Тамгын газар, Хууль Зүй, Дотоод Хэргийн яам, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Улсын Ерөнхий Прокурорын Газар, Улсын Дээд Шүүх, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Нийслэл дүүргийн шүүх, прокурорын газрууд, МУИС-ийн Хууль Зүйн Дээд Сургууль, Боловсролын Хяналтын Алба, Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Соросын сан болон бусад хамтран ажиллагч байгууллагуудад талархал илэрхийлж ажлын амжилтыг хүсэн ерөөе.

Сургуулийнхаа ахуй хангамж, үйлчилгээг сайжруулахын төлөө итгэл дааж, чин зүтгэл гаргасан ажилтан, ажилчиддаа мөн гүн талархал илэрхийлье.

*Манай сургуулийн нийт өнүгэл, залуус аа!*

Биднийг жолоогоо бат атган, ухааныг хүлгээ шавдан хурдуулж, номын хүрдэн оод урагшлан тэмүүлэхийн өлзий билигт ерөөлийг дэвшүүлье.

*Сургуулийг дүүргэсэн нийт төгсөгчид өө!*

Хүрсэн эрдэм, хүртсэн боловсролдоо бүү ханагтун! Та бүхэн насан турш Шинэхутуг сургуулиараа овоглох болно. Төрөлх сургууль чинь та бүхнийг номын хураар тэтгэн, хэрэгцээг мэдээллээр цэнэглээсн



хэзээд бэлэн байна. Угшил үндэргатай бүхэн хэзээ ч дундарсаггүй нь жам ёсон билээ. Манай сургууль зуун зуунд дамжин Монголын, бас ойрын ирээдүйд тив дэлхийн олон орны залууст эрдмийн шинээ хүртээх хэмжээнд хүрэх нь дамжингүй.

*Эрдмийн хур үргэлжийн мөнгөд хайлан бууж,  
намын хашиг буян бялхан цалгиж байх болтугай.*

## Шихихутуг бол Монголын төр, хууль цаазын үлэмж гарамгай зүтгэлтэн мөн.

*Натвэж: Доктор (Sc), профессор Ж.Балдбаатар*

Их Монгол улс, хүн төрөлхтний түүхэнд хүчирхэг байлдан дагуулагч хэмээгддэг Наполеон, Гитлер, Македоны Александрынхэйгч хамтатган нийлүүлснээс илүү 7 сая 770 мянган ам дорволжин нутгаар хаяа тээж, хүн амын их зонхи төвлөрсөн Хятад, Араб, Европын соёл иргэншилт орнуудыг Монголын эзэнт гүрэнд нэгтгэн, өрнө, дорныг улс төр, эдийн засаг, соёлын талаар холбож, төр ёс, хууль цаазыг тогтоож байсныг түүх өгүүлнэ. Эл үеийн хэрэгт үлэмжийн их Чингис хаан, түүнийг залгамжлагчид гол үүрэг гүйцэтгэсэн нь мэдээж бөлгөө. Тэднээс тална энэ үед нэгд; Чингис хааны хөвгүүд, ач нар, ах дүү, төрөл төрөгсдөөс, хоёрт; Тэмүжиний бага, залуу наснаас нөхөр, турхаг болон зүтгэгсдээс, гурант; байлдан дагуулалын үед монголын талд хүч ухаанаа өгсөн энэ бүрийн үндэстэн, ястны гаралтай түшмэл, цэргийн ноёдоос төрийн томоохон зүтгэлтнүүд тодорч, монголын төр ёсны түүхэнд балрашгүй ул мөрөө үлдээсэн юм. Ийнхүү нөхөр, турхаг болон зүтгэгсдийн нэг нь Чингис хааны өргөмөл дүү, цэргийн жанжин, их биегийн хүн, нэрт хуучин, төрийн эцэйн билэгт зүтгэлтэн Шихихутуг мөнөөс мөн.

Тэрээр эрдэмтдийн тооцоолон гаргаснаар 1180, 1181 оны орчим татварын нэгэн сурвалжит гэр бүлд хүй тасарч, хүмүүн зава залгажээ. Ийнхүү Шихихутуг хэмээх их хүний түмэн олной гийсний 920 сүүдэр тухайсааны их тэгш ой, түүний нэрээр овоглоосон сургуулийн 10 жилийн ойтой үлдсэндээ давхцаж байгаа нь ихээхэн бэлэг дэмбэрэлтэй юм. Түүх шашигт 1190 онд Тэмүжин Татарчуудтай байлдах үеэр алтан эзэмтэй, будган дотортой эрүүч өссөн нэгэн бяцхан хөвүүнийг цэргүүд олж, хандиа авчирч өгөхөд Чингис тэр хөвүүнийг байдал төрх ерийн хүрээс их л өөр учир Өэлүн эхдээ асруулан тэжээлгэхээр өгсөн тухай өгүүлсэн байна. Өэлүн эх тэр хөвүүнийг сайн хүний үр гэж үзэж, таван хөвүүнийхээ дүү зургадугаар хөвүүн болгоё гэж Шихихутуг хэмээх нэр хайрласан аж.

Монголчууд бэлэг дэмбэрэлийг бодож үр хүүхэддээ нэр хайрладаг. Судлаачид сайхь хөвгүүнд нэр өгснийг Шинг гэдэг нь чингийн хуруу мэт бяцхан, хуту гэдэг нь билэг төгөөдөр гэсэн үг хэмээн тайлбарладаг нь бодуштай, тал өгүүштэй таамаглал юм. Ийнхүү Шихихутуг хэмээх татарын нэгэн хөвүүн алтан ураг, цагаан ястны хамгийн ойрын хүрээлэлд багтсан ажгуу.

Шихихутуг төр, хууль цааз, цэрг, соёлын өргөн шар хүрээтэй үйл ажиллагаагаараа Их Монгол улс, эзэнт гүрний үеийн түүхэнд гүнзгий ул мөрөө үлдээсэн зүтгэлтэн учраас түүний амьдрал, үйл ажиллагааг дараах үеэснэ үеүдэд хуваан үзэж болохоор байна.

Үүнд:

*1. Бага, залуу нас, нийгэм-улс төр, үзэл санааны төлөвшил /1180-1206/:* Шихихутуг Өэлүн эх, Борто үжирний хайр халамжаанд бага наслаа өнгөрүүлж, талын язгууртны гэр бүлийн орчинд өсөн хүмүүжж, хүмүүн төрх суужээ. Тэмүжиний эсгий туургатныг нэгтгэхийн төлөө шаргуу тэмцлийн жилүүдэд Шихихутугийн бага, залуу нас тохиосон учир нийгмийн ийм орчин нь түүний улс төр-үзэл санааны төлөвшилд онцгой нөлөө үзүүлсэн байна. Өргөж авсан ах нар, алагува Тэмүжиний талбну

ухан, чин зориг, баатарлаг үйлэе Шинхутугийг өөрийн эрхгүй үлгэрлэн дагуулж байв. Тэрээр хар багасаа бат чийрэг, зориг чанга, харлаж намихдаа цэцэн мэргэн, овсгоо самбаатай болон өсч бойжиж байв. Энэ нь Персийн алдарт түүхч Рашид-Аддин тэмдэглэсэнчлэн 12 настай байхдаа Чингис хааны отгон хүү Тулуйг Бөртэ-Ужигий хамт хулгайчаас эр зориг, бяр хүч гарган салгаж авсан, 15 насандаа 30 буга хөөж, 27-г нь намнасан хэрэг эрхлэх явдалар тодорчээ. Тэр бас ер бусын оюун тол, ухаан сэргэлэн байсан бөгөөд уйгар бичгийг гарамгай сурчээ. Академич В.В.Бартольд: Чингис хаанд ойр дотно байсан хүмүүсээ татаар гаралтай, бага балчир байхдаа Чингисийн эхэл үрчлэлсэн Шинхутуг бусдаас түрүүнд уйгар бичиг үсэг, боловсрол сайтай эзэмшсэн байлаа<sup>1</sup> хэмээн тэмдэглэсэн байна.

Удалгүй Шинхутуг эрийн цэцэг хүрч, монгол олон овог, аймгуудыг аравсаа дагуулах Тэмүжиний тэмцэлд оролцон оролцож, үлэмж гавъяа байгуулж байсан байна.

"Монголын нууц товчоон"-нд Тэмүжин өргөмөл дүүтээ:

"Мэргэнийг мэдүүлж  
Монголыг мохоож  
Тайчуудыг таньж  
Дайсныг даралсан  
Татаарын Шинхутуг минь"<sup>2</sup> хэмээн

магтан соёргожээ. Цэгийн ороо бусгаа энэ үед Тэмүжин өргөмөл дүүгийнхээ чингч шулуун, ажигч гярхай, оюун гэгээрэнгүй, нягт, аливаа асуудалд давцтай хандаж чанарыг улам гүнзгий танин мэдэж, цаашид их хэргийг итгэн даалгаж болох итгэл найдварыг өвөрлөжээ.

2. *Монгол төрийн тухайн үргэлэлт, их бичгийн хүч болон төлөвшөн үе* /1206-1240/: 1206 онд Их Монгол улс байгуулагдсаныг Чингис хаан Шинхутугийг улсын дээд заргаар томилж, "үзэх нүд, сонсох чих болж явах"-ыг даалгаад, "Бүх улсын доторх хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, ялах ёстойг ялаж бай" хэмээн зарлиг буулгажээ. Түүнчлэн "Нийт улсын өмчийг хувааж, заргыг шийтгэж, түүнийгээ хөх дэвтэрт бичиж дэвтэрлэгтүүн. Надтай зөвлөж, Шинхутугийн шийтгээд, цагаан цавсан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн урант хүртэн үүрч хэн ч бүр өөрчилтгүй" гэж зарлиг болгосон нь Шинхутугт "Их засаг" хуулийн гол зохногч, хөдөлгөөн боловсруулагч байх яах аргагүй түүхэн үүргийг итгэн хүлээлгэжээ. Академич Б.Я.Владимирцов: "Чингис хаан хүмүүсээ гайхалтай таньж, өрлөг жанжууддаа хэрхэн зөв сонгож байсан шингээ ерөнхий шүүгчээ мөн л тийм аргаар зөв таньж олж авч чадсан"<sup>3</sup> гэж үзсэн байна.

Шинхутуг үйл ажиллагаагаа зөвхөн хууль ёс, журам дэглэм сахнуулах төдийгөөр хязгаарлаж байгаагүй, төрийн бүхий л тулгам үйл хэрэгт ухаанаа уралдуулж, санаагаа сааж байсныг олон баримтлар өгүүлж болно. Тухайлбал, 1234 оны I сарын 31-нээс 1235 оны I сарын 20-ны хооронд Умарт Хятадад амбан сайд Хутагын удирдлагын дор хүн амын тооллого явуулах тухай Өгэдэй хааны зарлиг гаргасан байна.<sup>4</sup> Бас өөр нэг сурвалжон: "Монголын түшмэл Шинхутугийг 1235-1236 онд Яньжинд очиж хүн амын тооллого явуулахад Өмнөт Сун улсын талөөлөгчид байлцсан"<sup>5</sup> хэмээн өгүүлжээ. Ийнхүү тэрээр зөвхөн хууль хяналтын ажил эрхлээд зогсоогүй, их гүрний засаг захиргаа, хүн ам, аж ахуй, эдийн засгийн хэргийг удирдан зохион байгуулах үйлсэд хичээнгүйлэн зүтгэж

байлаа. Мөн Их Монгол улсын гадаад байдлыг төвшинтөх, хама тэлэх хэрэгт цэргийн авъяаслаг жанжны хувьд оролцож, гарамгай гавьяа байгуулахын хамт мөн эрийн шинэжилт идэрхэг хүчиндээ эрдэж, ялагдахын зовлонг ч амсаж байсан юм.

Шихихутуг бас төрийн хэрэг, номын бунсыг ихэрлүүлэн зүтгэж, бичгийн мэргэнийг нэн даруу ёс ямбыг жудаг сахин бараж байлаа. Зарим судлаачид түүнийг "Монголын нууц товчоон" хэмээх гайхамшигт бүтээлийг туурвисан гэж таамаглах нь буй. Үүэндээ ч монгол овогтныг нэгтгэх тэмцэлд оролцож байсан цаг түүхийн амьд гэрч, эрдэм номонд гаршсан авъяас билэгтэй бичгийн мэргэний хувьд уг алдарт бүтээлийг туурвисан байж болзошгүй, үгүй юмаа гэхэд гар бие оролцсон нь дамжиггүй. Ямарар ч үзсэн өгүүлэн буй үед Шихихутуг цэргийн хэрэгт ид хав нэвт, эрдэм соёлд нягт хичээнгүй, цааз эрхэмжвил чанд хэрсүү төрийн эр, судрын хүмүүн болон төлөвшисөн нь бүх талаар нотлогдож байна.

**3. Их Монгол улсын их хаадыг шунталж, төр, хууль цаазыг хэрэгт зүтгэн, өөрийн дэг сургуулийг бий болгосон үе /1240-1260-аад он/:** Энэ үеийн эхэнд Шихихутугийн төр, хууль цаазын хэрэгт зүтгэсэн тухайд их ухаан, үзэмж тэвчээр тэгшперсэн цаг байлаа. Тэрээр чин үзэнч, чигч шударга чанар, бичгийн мэргэний уламзан болсон ухаарлын ачаар шүүх хууль цаазын өөрийн гэсэн дэг сургуулийг бий болгожээ. Рашид-Адин: "Тэр үеэс одоо хүртэл Могулистанд ч, бусад нутагт ч түүний арга, барилын зарчмыг шүүхийн шийдвэрийг үндэс болгодог нь заргачдын /шүүгчдийн/ маргаанаас тодорхой байна"<sup>23</sup> хэмээн тэмдэглэжээ. Энэ дэг сургуулиар Монголчууд төдийгүй, 720 хэлээр ярьдаг, 5 өнгийн улс түмнийг нэгтгэсэн, дэлхийн талыг эзэгнэсэн Монгол их гүрний бүх шүүгчид ажиглаж байжээ. Шихихутуг Мөнх хааны үеийн нэрт шүүгч Мөнхсар ноён, Хубилай хааны үеийн шүүгч Байжу, түүнчлэн Хятад, Перс зэрэг олон үндэстний шүүгчдийг өөрийн гараар сурган бэлтгэсэн аж.

Халимагийн нэрт түүхч Э. Хар-даваа: "Чингис хааны сонголт маш зөв болсон. Шихихутуг шүүгчийнхээ үүргийг үлгэр жишээгээр биелүүлж, зарим талаар өөрийнхөө зуунаас бүр халин гарч байжээ. Тэрбээр айхдаа өгсөн өчиг мэдүүлгэнд ямар ч ач холбогдол өгдөггүй байсан"<sup>24</sup> гэж бичжээ. Мөн академич Б.Я.Владимиров: "Шихихутуг үүрэгт ажлаа үлгэр жишээгээр биелүүлж байсан ба түүний ажлаасгай байдал бусад хүмүүст гайхамшигт сайхан үлгэр дуурайлал болж өгчээ"<sup>25</sup> хэмээн тэмдэглэсэн байна. Шихихутуг насан хувиц шалгиин тулгамд Чингис, Өгэдэй, Гүюг, Мөнх хааны үеийн төр, цааз эрхэмжийн үйлсэд чин шударгаар хүчин зүтгэж, Хубилай хааны нүүрийг үндэс. Хүлэг эцэг, хүн харьдаг нь жам ёсон. Тэрбээр насны эн, үйлийн ихэд даргалж, 82-ны сүүдэр зөөглөсөн байна. Улсын их заргач Шихихутуг "Айж, цочин хэрэг хүлээх хэрэггүй", "Айлтгүй үнэнээ хэл" гэж хэрэгтэн хүмүүст нэг биш улаа давтан хэлдэг байсан нь гэм эрдэм байвч, сэтгэл нь далай мэт байснах буй ээ. *Чингис хааныг эг товчооно Шихихутугаас өөр өөрийнхөө дэг сургуулийг бий болгон дэлхий дахинаа хрээни зохиоворүүлж, олон улс түмний төрийн түрэмх, шүүгчдийг ухаан, арга барилуураа арвасаа долуулж байсан төрийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэд Монголын түрээд урьд хөгжид ч, өдгөө ч гаргалгүй гэж бардлагаар хэлж байна.* Ийнхүү Шихихутуг бол Монгол төрийн алтан буулга мэт хууль цаазыг магадлан боловсруулагч, чандлан сахилдагч, зансигнын хамгаалагч, төрийн хэргийг номоор засахыг

дээдлэн эрхэмлэгч төрийн үзэмж агуу, сэнэн билэгт зүтгэлтэн байжээ. Түүний ухаан билэг нь уужим тал мэт талбиу, бодол сэтгэлгээ нь их далай мэт гүн, арга барил нь жам ёс мэт зохиронго, хүмүүн төлөв нь өндөр уул мэт түшигтэй, улс төрийн нуруу нь төв эрхэмсэг байчуухуй. Ийм учраас тус сургууль үлэмж их хүн Шинххутугаар овоглосон юм. Тэгэхлээр манай сургуулий профессор багш нар, оюутнууд, төгсөгчид нь:  
- Шинххутугийн төр, цааз эрхэмжийн үзэл санааг гүнзгийрүүлэн судлагчид,  
- Шинххутугийн хууль цаазны үйл хэргийг нэр төртэй залгамжлан үргэлжлүүлэгчид,  
- Шинххутугийн үзэл санаа, үйл хэргийг өдгөөгийн нөхцөлд шинэ агууллагаар байжуулан мөнхлөгчид мөн.

Бид Шинххутугийн номын үр сад. Бид иргэний ардчилсан нийгэм эрх зүйт төрийг төлөвшүүлэхийн төлөө нэгэн үзүүрт сэтгэлийг барин, хатамжлан зүтгэсэд. Аугаа их төрийн түшээ Шинххутуг Таны авьяас билэг, сод ухааны лянхуа ашид мөнх дэлгэрэн цэцэглэж, төр, түмэндээ, номын үр сад бидэндээ буян хишиг өгөөжөө үеийн үед хайрлаж байх болтугай!

## Монголд хуульч үндэсний мэргэжилтэн бэлтгэсэн түүхэн асуудал

*Нэмэгдэж: Доктор (Sc), профессор О.Амаргүү*

"Хуульч" гэсэн нэр томъёогоор илэрхийлэгдсэн үгийн шал агуулга багтаамж нь хуулийг мэдэх, ойлгох, хэрэглэх, сахих арга ажиллагааны гол тулгуур хүч гэсэн санаа мөн. Ингэхлээр Үндсэн хуулиараа эрхэм зорилго болгон дэвшүүлэн тавьсан иргэний арчилсан нийгэм, эрх зүйт төрийг монгол орондоо ногцлуулан бүтээн байгуулах их хэргийг гардан хэрэгжүүлэгч мэргэжлийн нөөц нь хуульчид гэж үзэж болно.

Бидэнд төдийгүй дараагийн үеийнхний өмнө тулгарсан нийгмийн шинэ байгуулалд энэхүү том зорилгыг шийдвэрлэх нөөц урсгалаар гэнэт бий болоогүй нь ойлгомжтой. Үе шаттай, зохион байгуулагдтай, ухамсартай бодлогоор дамсын ажлын аажмаар хуримтлагдсаар өнөөгийн тавшанд хүрч ирсэнийг түүх аяндаа өгүүлж байна.

Монголын төрийн үйл хэргийг хамжилгах, түшиглэх хуульч мэргэжилтэй үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, сургах арга ажиллагааг цаг үеийг туулан хөгжин боловсорсон, төрийг төлөвшүүлдэхэд чиглэсэн төрийн бодлогын нэгэн томоохон арга хэмжээ байжээ гэж хэлж болно. Харин зарим хуульч эрдэмтний тэмдэглэн бичсэнчлэн түүхэн нэгэн удирдагчийн товойсон гавьяа хараахан биш бололтой /С.Жалан-Аажав, Э.Авирмад "Эрх зүй" сэтгүүл, 2001.УБ.№4-5, 7-8-р талд дэлгэрэнгүй үзнэ үү/.

Хуульч үндэсний мэргэжилтэн бэлтгэж ирсэн асуудлыг бага гэхгүйгээр шинжлэх ухаанаар авч үзэх нь Монголын эрх зүйн тогтолцооны судалгаа, хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн хандлагыг зөв зохиистойгоор тодруулахад ач тус үзүүлнэ.

Бид энэ асуудалд хандахад нийгмийн шинжлэх ухааны аль ч салбарт хэрэглэдэг орчин цагийн судалгааны өгөөжтэй, ирээдүйтэй аргыг хэрэглэх нь зохиистой. Тийм аргад юуны өмнө "paradigm" буюу алгуур хувьсал хөгжлийн арга; "compare" буюу жиших арга аль аль нь эн чануу хэрэглэгдэх болов уу.

Хуульч мэргэжлийн үндэсний боловсон хүчин бэлтгэж ирсэн асуудлыг дээрх аргад тулгуурлан авч үзвээс дараахь дүр зураг мэдрэгдэж байна. Үүнд:

Танхимын сургалтгүйгээр үйлдвэртэлд шууд дадлагажуулах сургалт /Монголын нэгдсэн төр үүсэн тогтсон үеэс эхлэн 1950-иад оны эхэн үеийг хүртэлх хугацааг хамарна/

Дадлагажуулах сургалтыг танхимд тусгай мэргэжлийн дунд боловсрол эзэмшүүлэх сургалттай хослосон сургалт /1950-иад оны эцэс хүртэлх хугацааг хамарна/

Танхимын сургалтаар дээд боловсрол эзэмшүүлэх сургалт /1950-иад оны сүүлчээс 1990-ээд оны үеийг хамарна/

Дээд боловсролын сургалтыг төрийн өмчийн зэрэглээгээр хувийн өмчийн хэвшилээр хослон явуулах сургалт /1990-ээд оны эхэн үеэс хойших хугацааг хамарна/ гэсэн дөрвөн үндсэн үе шатад ангилж болмоор санагдана.

Эдгээрээс хлэвч үе шат түүхийн хувьд ч, нүүдэлчдийн соёл иргэншлийн хувьд ч илүү анхарах татаж байгаа юм.

Монголын нэгдсэн төр анх үүсэн тогтсон эхэн цагаасаа төрийн хуулийг чандлан биелүүлэх, зөрчил гажуудал гарч хүний эрх зөрчигдөх алаас төрийн нэрийн өмнөөс шүүн тунгаах, асуудлыг нэгэн тийш шударгаар шийдвэрлэх хариуцлагатай алба бий болгож, уг албан тушаалыг "улсын их заргач" хэмээн нэрийдэж, түүнд Шинжлэлт гэдэг хүнийг томилон ажилдуулж, хуулиа дээдэлж ирсэн түүхэн зурвас үеийн тухай доктор, профессор Ж.Болдбаатарын тавьсан сонирхолтой илтгэлд сэтгэл нэн хангалуун байна.

Эр нь монголчууд хууль цаазын сэтгэлгээ сайтай, мэдрэмж өвчөртэй, уламжлал арвинтай байсныг эзэн Чингисийн "Их засаг" хуулиас авахуулаад Монголын их, бага хвадмын үеийн хуулиуд, "Халх журам", "Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг" зэрэг өөрийн өвөрмөц онцлогтой, нэр хүндтэй, олон улсын болон өөрийн орны судлаачдын анхаарал, сонирхолыг ихээр татсан түүхэн баримтууд илтэд нотлон харуулаар бичгийг хүрч ирлээ. Энэ бол мэргэжлийн хуульчид бэлтгэх арга ажиллагаанд ихээхэн эерэг нөлөө үзүүлсэн гэж үзэж болно.

Монгол төрийнхөө хуулийн гэх албыг хашсаар ирсэн үе үеийн овог дээдэс, ахмадууд маань "хуульч" гэсэн мэргэжлийн диплом үгүй цаг хугацаанд алаа эндэгдэл олтгоодол осолдол багатайгаар, шударга үнэний мөрөөр хичээнгүйлэн ажилласаар ирсэн нь Монгол хүний оюун ухааны багтаамж арвин, авъяас чадвар төгснийг илтгэнэ. "Хөх дэвтэр", "Улаан хашарт" хэмээх хууль цаазны түүхэн сувар зэрэг албан ёсны баримт бичгээс эхлээд, зарга маргаан шүүгч цэцэн мэргэн ноёд, түшмэлийн тухай үлгэр, домог ч үүнийг давхар гэрчилнэ.

Энэ бүхнээс үүдэлтэйгээр Монголын эрт эдүгээгийн хууль цааз, эрх зүйн тогтолцоо, түүнд боловсорсон мэргэжлийн хүчний аль алиных нь тухайд Монголын гэсэн ямар онцлог байгаа гэдгийг шинжлэх ухаанчар авч үзэх нь бичигд мнөгдсөн түүхэн үүрэг мөн.

Монгол аймгуудын бичигдмэл болон ердийн хууль цааз, Монголчуудын хууль цаазын дурсгалт бичгүүдийн талаар бүр 1600-гаад оноос 1930-аад оны дунд үе хүртэлх хугацаанд судалгаа шинжилгээ хийж, санал дүгнэлтээ хэлсээр ирсэн Араб, Перс, Армений түүхч, шаштөр зохиогч Макризи, Мирхоненд, Ибн-Батут, Рашид-Адин иар болон Оросын эрдэмтэн Владимирцов, Попов, Резановский, Жамцарано нарын бүтээл туурвилд "Жинхэнэ Монголчуудын хууль цааз" гэсэн утга санаа, томъёолол олонтоо хэрэглэгдэж байсныг бид анхааралдаа авахгүй байж боломгүй. Дэлхий нийтэд тогтож хэвшсэн мэдлэгийн хүрээнд бид өнөөдөр Англо-Саксоны, Ром-Германы эрх зүйн бүлийн хэмжээнд л эргэлдэж байгаа билээ. Гэтэл цаана нь Монголын эрх зүй гэсэн гуравдахь бүрхүү дээрх хоёр бүтээс онцлог ялгаа бүхий бас нэгэн бүл байгаа юм биш бизээ гэдэгт ч эрэл хайгуул хийх шаардлага гарч байна. Үүнтэй холбосдуулан доктор (Sc), профессор Т.Сэнгэдоржийн "...манай хууль цааз нүүдэлчдийн хэмээх эрх зүйн өвөрмөц систем байсан" /"Эрх зүй" сэтгүүл, 2001, №4-5, 12-р талд харна уу/ гэж тэмдэглэснийг гүнзгийрүүлэн авч үзэх хэрэгцээ ч байж болно.

Энэ бүхнийг дурьдсаны учир нь хуульч болгох дадлагын сургалт тэднийгүи онолын сургалт ч гэсэн өөрийн гэсэн онцлогоос тасрахгүй баймааж нь шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн аль алинд нь өгөөж сайтай байх учиртай санааг л илэрхийлэх гэсэн юм.

*Хоёр дахь буюу дадлагажуулахыг татхимыхтай хослуулах*

сургалтын үе шат нь шүүх, прокурорын зэрэг байгууллагад алба хашиж байгаа ажилтнуудаас цаалин хөлсийг нь хэвээр хадгалж нэгэн жилдйн хугацаагаар танхимд онолын мэдлэг эзэмшүүлэх сургалтанд хамрааруулах арга хэмжээ байв.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1950 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор Шүүх-Прокурорын ажилтныг бэлтгэх хууль цаазны сургууль байгуулахыг Улсын Прокурорын газар, Шүүх яаманд зөвшөөрчээ. Энэ тогтоолд уг сургуульд нэг жилд элсэн суралцах суралчдын тоог 30 байхаар заасан байна.

Тус сургууль үр дүнгээ өгч байсан учраас түүнийг 8 жилийн дараа өргөтгөж, Сайд нарын Зөвлөлийн 1958 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 134 дүгээр тогтоолоор суралцах хугацааг 3 жил болгож, элсэлтийг жил бүр 80 хүн байхаар заажээ. Үүнийг Шүүх яамны харьяа Улаанбаатар хот дахь Хууль цаазны дунд сургууль гэж нэрийдэж байсан бөгөөд 90-ээд оны дунд үе хүртэл хууль зүйн тусгай дунд боловсрол олгох үүргээ гүйцэтгэсэн байна.

Энэ сургуулийг төгсөгчид шүүх, прокурорын байгууллагад төдийгүй төр, захиргааны болон боловсрол, шинжлэх ухааны байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, тэднээс олон хүн "Монгол Улсын гавьяат хуульч" нол хүртсэний гадна Г.Сова, О.Амархүү нар хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор боллоо хөдөлмөрдөснийг тэмдэглэн хэлэх нь зүйн хэрэг. Эдгээр баримт бол тус сургуулийн сургалт, хүрүүжлийн ажлын чандарыг илтгэх нэгэн жишээ юм.

*Гурав дахь бүтэц дээд боловсрол эзэмшүүлэх сургалт нь найгмийн хэрэгцээ, захиралгаар бай болсон үе шат* гэж үзэж болно. Тэр үед ЗХУ-д хуульч мэргэжлээр бэлтгэгдсэн дээд боловсролтой үндэсний мэргэжилтэн 10 гаруй хүн ажиллаж байсны дээр Хууль цаазны дунд сургуулиар ахмад болон залуу үеийн 300-аад хүн бэлтгэгдэж, тэднийг дараагийн шатны сургалтанд хамруулах хэрэгцээ аяндаа бий болсон байв. Түүнчлэн төр, эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн үндэс суурийг ч баталган бэхжүүлэх шаардлага бас тулгарчээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны 1957 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 301/202 дугаар тогтоолоор Улсын Их Сургуулийн найгмийн ухааны факультетэд хууль цаазны ангийг 1958 оноос эхлэн байгуулахыг Шүүх яам, Улсын Их Сургуульд аялгагсан байна. Үүний дагуу анх 35 оюутан, 2 багштайгаар сургалтын үйл ажиллагаагаа эхэлж байжээ. Дараа нь Сайд нарын Зөвлөлийн 1963 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 567 дугаар тогтоолоор УИС-ийн хууль цаазны салбарыг өргөтгөж, төр, эрх ба толорхой эрх судлалын хоёр тэнхимтэй болгохоор шийдвэрлэжээ. Мөнхүү тогтоолоор хууль зүйн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний ажлыг Улсын Их Сургуульд төвлөрүүлсэн юм. Чухам энэ үеэс хууль зүйн дээд боловсролын сургалт, эрдэм шинжилгээний ажлын гүнжин холбоос нэгэн цэгт зангиагдаж эхэлсэн түүхтэй. Үйл явц өрнөн дэгжсээр өдгөө МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 2000 оны эцсийн мэдээгээр дээд боловсрол бүхий 2000 гаруй хуульчиг төгсгөж гаргасан, одоо 1000 гаруй оюутан, 40 гаруй үндсэн багш, ажилтантай, мэргэжлийн 5 тэнхимтэй эрдэм уурхайн нэгэн том айл болж, тэрхүү өрх гэрйг академич С.Нарангэрэл тэргүүтэй явагч тэмдэглэн хэлэх нь хуульч бидний бахархал гэж үзвэл зохино. Хууль зүйн дээд сургуулийн өсөлт, хөгжил, бэхжилтэд тухайн үеийн ЗХУ болон



өнөөгийн Оросын Холбооны Улсын хуульч эрдэмтдийн оруулсан хувь нэмэр, ач тусыг бид энэ дайрамд цохон дурдах нь шуларга үйлсэд нийшлэ.

Үндэсний Их Сургуулийн зэрэгцээгээр дээд мэргэжлийн хуульчдыг ЗХУ-д олноор бэлтгэж байсан нь хууль зүйн шинжлэх ухаан, практик үйл ажиллагааны хөгжсөд чухал ач холбогдол үзүүлсээр ирсэнийг цохон тэмдэглэх нь зүйтэй. Одоо ч энэ ажил гагцхүү ОХУ-аар хязгардаггүй, дэлхийн өнцөг булан бүрийн өндөр хөгжилтэй бусад орнуудын хүртэл өргөжөн тэлж байгаа нь сайшаалтай хэрэг мөн.

МУИС-ын Хууль зүйн сургууль төгсөгчдөөс олон арван хүн гавьяат хуульч цол хүртээд байгаагийн зэрэгцээ академик С.Нарангэрэл, шинжлэх ухааны доктор, профессор Т.Сэнгэдорж, И.Дашням, Д.Лүнсэжжаниан, Ж.Амарсанза, Л.Балсан, дэд доктор Б.Чимид, Н.Жаншан, С.Төмөр нарын зэрэг 30-иад эрдэмтэн төрөөд байгаа нь хувь хүний оюун ухаан, хичээл зүтгэл, хөдөлмөр бүтээлийн ач гавьяа төдийгүй сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн нэгдлийн чанарын үзүүлэлтийг харуулж буй хэрэг мөн.

*Дөрөв дэх буюу төрийн өмчийн зэрэгцээ, хувийн өмчийн сургалтыг хөдөлгөн үе шат* бол хуульч дээд боловсролтой үндэсний мэргэжилтэн бэлтгэх арга ажиллагаанд гарсан шүү шинэ, лэвшилтэт алхам болсон юм. Энэ бол Үндсэн хуулиараа тусгаглан баталгаажуулсан нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг төр хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах эрх зүйн үндэс суурь дээр баттай тулгуурласан найдвартай, ирээдүйтэй алхам мөн.

1991 онд санаачлагчдын хувийн өмчөөрөө байгуулсан "Шинжлэх" Хууль зүйн дээд сургуулийг тэр үеийн Шинжлэх ухаан, боловсролын яамны сайдын Зөвлөлийн шийдвэрээр сургалтын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч байсан цаг үеэс хойш ердөө л 10 жил өнгөрөөд байна. Энэ сургууль дээд боловсролтой хуульч мэргэжилтнийг Монголодоо хувийн хэвшлийн сургуулиар бэлтгэх шинэ ажлын анхны хошуучлагч нь болсон бөгөөд тавьсан зорилтдоо хүрч болдогыг цагийн шалгарлаар данж гарсныг тус сургуулийн захирал Д.Оюунцэцэгийн саймы тавьсан илтгэл харууллаа гэж итгэлтэйгээр хэлж болно.

Ийнхүү хуульч мэргэжилтнийг төрийн өмчийн дээд сургуультай зэрэгцэн хувийн хэвшлийн дээд сургуулиар бэлтгэх дэвсий нийтийн хөшөг Монгол оронд төлөвшин тогтов. Ийм сургуулиуд шил шилээ даран олширсоор байна. Гагцхүү чанарыг л эрхэмлэх ёстой.

"Шинжлэх" ХЗДС-ийн сургалтын нэг онцлог нь онол, категориудын тогтсон мэдлэгийг ердийн хэвшмэл аргаар оюунуудад сургах механик аргаас аль болохоор хөндийрч, оюутныг бие дааж өөрийгөө боловсруулах асуудалд шүүмжлэлтэй хандан, сэтгэх, дүн шинжилгээ хийх чадварыг нь нэмэгдүүлэх аргад аажим аажмаар шилжих сургалтын өрөөн цагийн тийм аргыг хэрэглэхийг чухалчлан эрмэлзлэгт оршино. Сургалтын нийм аргыг боловсролын талаарх өндөр хөгжилтэй орнууд "оюутан буюу шавь төнтэй арга", "participation method буюу оролцооны арга" гэж нэрлэн мэргэжүүлэн эрдэмжүүлэх чиглэлээр өргөнөөр хэрэглэх болов.

Сургууль байгуулагдсанаас хойшхи хугацаанд 250 гаруй бакалаврын зэрэгтэй, хуульч мэргэжилтэн бэлтгэсэн ажилтлаар шинэ мянгантай золголоо. Бид иргэний тасралтгүй боловсролын тогтолцоог цаашид сургуульдаа бүрдүүлэх алсын бодолтой байгааг юм. Манай

төгсөгчдөөс өнөөгийн байдлаар бакалаврын дараагийн баатны сургалт, магистрантуурыг 15 хүн төгсөж, олоо 17 хүн суралцаж байгаагийн дээр докторантурт 2 хүн суралцаж байна. Манай төгсөгчдөөс 19 хүн эх орныхоо хууль зүйн дээд сургуульд багшилж байна. Энэхүү статистик үзүүлэлт нь тус сургуулийн сургалт-шинжилгээ судалгаа-үйлдвэртэй гэсэн гурвансан пивжин холбоосын агуулга зорилт өндөрөг байгаагийн нэг баримт гэж хэлж болох юм.

Хууль зүйн дээд боловсрол олгох сургалтын бүтэц, арга зүй, орчин цагийн шинэ ололт нэвтрэн эхэлж буй өнөөгийн нөхцөл байдалтай холбогдуулан чанартай сургалт, төгсөлтийн төлөө зарим нэг саналыг Та бүхэнд томилуулахыг хүсэж байна. Тухайлбал, онолын суурь мэдлэг гэж нэрийдсэн төр-захиргаа, эрүү, иргэний нийм гурван эрх зүйн мэдлэгээр улсын шалгалт авч төгсгөж байгаа өнөөгийн практикийг өөрчилмөөр байна. Ер нь "Улсын шалгалт" гэсэн хэвшил хэв загварыг сургалтынхаа агуулгад тохируулан өөрчлөх цаг болоод байгаа биш үү гэж бодож байна. Оюутнууд сургалтын явцад улсын шалгалт авдаг хэмээхүүдэд тэдхүү анхаарч, бусдыг төдийлөн хайхрахгүй байх хандлага түгээмэл болсон нь мэдлэгийн цар хүрээг хумихад хүргэж байна. Энэ нь эрх зүйн нийт тогтолцоонд онол, судалгааны гүнзгийрэн мэргэшэх сэтгэл зүйг төлөвшүүлэхэд сүрхий саад учруулах зортой. Ийм байдлаас ангижирч байх бид хэвхэнэ хуульч мэргэжилтнийг бэлтгэж чална.

Иргэний нийгэм, эрх зүйт төрийн нөхцөлд хуульчид бол нийгмийг цэвэршүүдэх, эрүүлжүүлэх өргөн цар хүрээнд өндөр ёс суртахуунтай ажиллах учиртай. Тийм болохоор хууль зүйн их, дээд сургууль төгсөгчдөөс эрх зүйн зөвхөн дээр дурьдсан салбаруудаар шалгалт авч байх нь учир дутагдалтай юм. Дэлхийн олон улс орны анхааралд орсон бизнесийн эрх зүй, экологийн эрх зүй, хөдөлмөр, нийгэм хангамжийн эрх зүй гэх мэт хүний амьдрал, эрх, эрх чөлөөг төрөөс хангаж хамгаалах асуудалтай олон талаар шууд уялдам эрх зүйн мэдлэгээр, түүнчлэн нийгэм, улс төрийн болон орос, англ хэл зэрэг гадаад хэлний мэдлэгээр сургууль төгсөлтийн шалгалт авдаг журамд орох нь ач холбогдол өндөртэй байх болно гэж үзэж байна. Үүнийг манай сурган хүмүүжүүлэгчид, хуульч-эрхэмчид, сургалтыг үүслээс нь Шүүх яам нэртэй байхаас эхлээд мэргэжлийн удирдлагадаа байлгаснаар ирсэн, олоо ч тийм байгаа өдгөөгийн Хууль зүй, дотоод хэргийн яам, мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам анхааралтай авч үзэн гэдэгт найдах байна.

## Дээд боловсрол хорин нэгдүгээр зуунд

*Илтгэгч: Доктор (Ph), профессор Б.Тула*

1990-ээд оноос манай оронд өрнөсөн ардчилсан өөрчлөлт шинэчлэл нь хүнийг хувь хүнийх нь тухайд бүхэл л талаар хөгжих хөгжлийн шинэ үеийг нээсэн бөгөөд боловсролын салбарыг глобалчлалын түгээмэл зүй тогтлын замд гаргасан юм.

Нөгөөтэйгүүр XXI зуун нь мэдээллийн их эрин үе бөгөөд хүн төрөлхтөний болон монгол улсын инийгэм-түүхийн өвөрмөц нөхцлийн өнөөгийн шаардлагын дагуу боловсролын зорилго шинэчлэгдэн томъёологдож, их сургууль, коллежоор бэлтгэн гаргах мэргэжилтэй боловсон хүчний үйл ажиллагаа өөрчлөгдөж, орчиндоо дасан зохицох чадвартай, юмар ч нөхцөлд оногчтой шийдвэр гарган бүтээгчээр ажиллах чадвартай мэргэжилтэн болгох явдалар тодорхойлогдож байна.

XXI зууны боловсрол нь энэрэнгүй, хүмүүнлэг мөн чанартай, прагматик шинэстэй байхас гадна хүн хүнтэйгээ харилцах ур чадвар, соёлын хэрэглүүр байх чиглэлээр шинэчлэгдэж байна.

Учир нь "машин техник" хүний амьдралд илүү ихээр нэгтгэрч, илүү нарийн үүргийг гүйцэтгэж байгаа нөхцөлд цагийг илүү үр бүтээлтэй ашиглах чадвартай иргэд энэ цаг үед улам ихээр хэрэгтэй болж байна.

Хүмүүсийн хоорондын ялгаа /хөгшин, залуу, баян, хоосон г.м./ илүү тодорхой харагдах болж, тэдгээрийн биесээ тэвчих байдал нь улам багасаж байгаа тийм цаг үе нь өөрийгөө бусдын оронд таних чадвартай, нээлттэй, хамтын хөдөлмөрийн харилцааг бүхий л хүмүүстэй бий болгох чадвартай иргэдийг зүй ёсоор шаардаж байна.

Энэ үүднээс авч үзвэл боловсролын хүрээ, түүний субъектүүдийн үйл ажиллагааны менежмент нь зөвхөн мэдлэгийг олгох номлол, үзэл баримтлал, технологи, удирдлагаас бие хүнийг хөгжүүлэх, төлөвшүүлэх зорилго руу илүүтэй хандах хэрэгтэй нь харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, оюутны хэрэгцээ сонирхлыг өрнүүлэн бүтээгч идэвхи, дотоод сэдлийг хөгжүүлэх сургалтын арга, хэлбэр, хэрэгслүүрийг оногчтой сонгох, эцсийн дүнд үлс нийгэм, шинэчлэх ухаан техникийн хөгжлийн үндсэн хандлагыг урьдчилан харах, шинээр үүсэн гарч байгаа аливаа асуудал, нөхцөл байдлыг сөрөг мэдэрч, өмнөө тавигдсан зорилго, зорилтуулыг бүтээгчээр шийдвэрлэж ажиллах чадвартай боловсон хүчин бэлтгэх нь мэргэжлийн боловсролын улсын болон хүнийн их сургууль, коллежуудын гол зорилго болж байна.

Боловсрол нь хүний насан туршидаа суралцах үйл хэрэг гэдгийг бид тэр бүр ухаарахгүй, зөвхөн дээд боловсрол олж авахыг шүтээнээ болгон, суралцах богинохон хугацаандаа юу сурах ёстой вэ гэдгийг л хэлүүдэж, харин хүн өөрөө цаг үргэлж шинийг эрэлхийлэн суралцах ёстой гэсэн гол асуудлыг тэр бүр анхаарахгүй байна. Тухайлбал, хүн өөрийгөө уяирдан жолоолож, суралцах ур чадвар, арга замыг эзэмших хандлагыг нь хөгжүүлэх талаар дээд боловсролын байгууллагууд орхигдуулах хандлагатай байгаад асуудлын гол оршиж байна.

Нөгөөтэйгүүр, судлаачдын үзэж байгаагаар болон бодит байдлаас харахад өөрчлөгдөж байгаа ертөнцөө даван гарах хүний чадвар улам бүр хоцрогдсоор байна: Иймээс үргэлжлэн байгаа өөрчлөлтийн нөхцөлд зохиож амьдрахад шаардагдах чадвар, ухаанаар өнөөгийн дээд

боловсрол эзэмшигчдийг "зөвсгөлэх" ихээхэн хүч шаардсан үе болоод байгаа бөгөөд үүнийг энэ зуунд боловсрол эзэмшигчдийн өмнө тавигдаж байгаа томоохон хэрэгцээ шаардлага гэж ойлгож болох юм.

Сүүлийн үед гарч буй сэтгэл судлал, СХУ, боловсрол судлалын ном зохиолуудад хүн биеэ бүрэн дүүрэн хөгжүүлэх нь даян дэлхийн хүн төрөлхтөний чухал хэрэгцээ болсоныг олонтоо дурьдах боллоо. Гэхдээ ихээхэн хэмжээний мэдээлэл цуглуулсан хүнийг боловсролтой, мэдлэгтэй гэж оношлох нь өрөөсгөл бөгөөд гагцхүү мэдлэг нь өсөж нэмэгдэхийн хэрээр түүнийгээ эвч зүйтэйгээр ашиглаж чадах оюун ухааны чадавхтай хүнийг боловсролтой хэмээн хэлэх ёстой юм.

Аливаа нийгэм нь дээд боловсролыг тухайн нийгмийн хөгжил, дэвшилд хэрэг болохуйц хүмүүсийнхээ хөгжөөж боловсроход чиглүүтэн хэрэглэсээр ирсэн.

Хэдийгээр дээд боловсролын асуудал нь соёл иргэншлийн нэгэн адил эртний бөгөөд насанд хүрсэдийн боловсролын асуудал манай оронд сургалт практикийн тодорхой тогтолцоо болоод зургаа дахь арван жилдээ яаж байгаа боловч уг боловсролд бусдаас ялгаатай технологи байх ёстой гэсэн ойлголт хөгжлийнхөө эхний үе шатанд явж байна.

Өнөөдөр XXI зууны Монгол улсын дээд боловсролыг дэлхийн олон улсын боловсролын нийтлэг жишигт нийцүүлэн өөрчлөх, тэр тусмаа глобалчлал хэмээн нийтээр ярьж бичиж байгаа энэ үед дээд боловсролын технологийн шинжлэх ухааны үндсийг ярихыг урьтал болгохгүйгээр ихээхэн хэмжээний дорвитой судалгаануудыг хийж харьцуулан судлах хэрэгцээ шаардлага нэгэнт бий болжээ.

Учир нь аливаа тодорхой бусыг тодорхой болгохын тулд хүч зориг авьяас билгээ харамгүй зориулж, тэсвэр тэнцээртэй байж чаддаг, шинэ зүйлийг эрж хайгч судлаачдын хувьд энэ цаг үе нь шинжлэх ухааны хөгжлийн хамгийн их сэтгэл хөдөлгөөсөн, сонирхолтой үе ирсэнтэй холбоотой юм.

Шинжлэх ухааны шинэ нээлтүүд гарч байгаагай холбоотойгоор мэдлэг "хуучирч" их сургууль, коллежид олж авсан мэдлэгийн зарим хэсэг оюутнуудын төгсөх үед нь ач холбогдлоо алдаж байна.

XXI зууны хөгжлийн алхам улам хурдсаж энэ шинэ нөхцөл байдлын хувьд тухайн хүний 20-нод насандаа олж авсан мэдлэгийн ихэнх нь 40 нас хүрэх үед нь хуучирсан байх ба 20-нод насанд нь гарч байсан эрч хүч, үр бүтээл нь 30-аад насны үед ашиггүй болж болох юм.

Ингэхдээ дээд боловсролыг олгох явцыг мэдлэгдэж байгаа зүйлийг дамжуулахад чиглүүлэх бус харин орчин үед үл мэдэгдэх зүйлсийг нээн нэрүүлэхэд туслэх зэрэг төсгөлгүй үйл яви хэмээн ойлгож болно.

Тиймээс ч багш нарын зүгээс оюутны суралцах хугацаанд шинэ мэдлэгийг тэр бүр өгч чадахгүй нь ойлгомжтой учраас оюутанд тасралтгүй суралцаж, өөрийгөө боловсруулан хөгжүүлж, мэдлэг эзэмшиж арга барилд сургах нь өнөөгийн дээд боловсролын гол асуудал нь болж байна.

Бидний өвлөж авсан ойлголтонд боловсрол гэдэг нь мэдээлэл дамжуулалт, суралцах гэдэг нь хүрмэгцүүлсэн баримтаа зураг тархиндаа хадгалах оюун санааны онцгой үзэгдэл хэмээн үзэх хандлага ноёрхож байлаа. Энэ нь сурх гэдэг нь үндсэндээ гадаад үйл яви бөгөөд суралцагчийн сурч буй зүйл нь багшийн үр чөлөөр, уншиж буй материалын чанар, тухайн сургуулийн программын үр өгөөж гэх мэт гадаад хүчин зүйлээр тодорхойлогддог хэмээсэн ойлголт юм. Энэ

ойлголтгүй аль ч талас нь авч үзсэн зөвхөн багшийн хичээл заах ёстой гэсэн үүргийг л тодорхойлж байгаагаас бус оюутны үүргийн тухай бараг дурсах ч үгүй байна.

Өнөөдөр манай бүх шатны сургуулиудад багшилж буй боловсон хүчинд ажиглагдаж нийтлэг дутагдал нь суралцагсдад зөвхөн мэдээлэл дамжуулах замаар мэдлэгийг олгодог арга барилыг чухалчилдаг нь нууц биш юм. Өөрөөр хэлбэл, мэдлэгийг дамжуулдаг, юу мэдэх ёстойг нь хэлж өгдөг, түүнчлэн сурч боловсроход нь татан оруулдаг гэсэн "тусламж"-ийн шинжтэй байдал нь давамгайлж байгаа бөгөөд бид энэ хандлагаасаа хөгжүүлэх хандлага руу түлхүү анхларах нь зүйтэй юм.

Бидний өнөөдрийн алхан орж байгаа XXI зуунд багшийг заах гэсэн үгээр тодорхойлохгүйгээр, багшлах суралцах үйл явцын бүхий л хариуцлагыг зөвхөн багшид үүрүүлэхгүйгээр, харин дээрхийн эсрэгээр дуудлын хариуцлага болгон багшийн үүргийг хамтран судлагч, чиглүүлэгч, хөгжүүлэгч, удирдагч хэмээн үзэх хандлагыг улам хүчтэй болгох шаардлага зүй ёсоор гарч байна.

Эцэст нь тэмдэглэхэд, өнөөгийн дээд боловсрол эзэмшигчид ухаалаг байдал, хүч чадал, эрх чөлөө, өөрөөр өөрийгөө нээх, илэрхийлэх авъяас, бүтээж туурвиж түүнээсээ таашаал хүндэтгэл хүлээж, амьдралыг илүү их утга учир бүхий гэрэл гэгээтэй болгохыг зорьдог, хамаг л сайн сайхан, баяр баясгаланг мэдэрч, амьдарч буй орчингоо таатай уур амьсгалаар хүрээлүүлэгчид байх учиртай.

## Гадаад хэлний сургалтын Оюу практикийн асуудлууд

Натгэч: "Шихихуту" ХЗДС-ийн  
сургалтын албаны дарга Г.Уламбаяр  
(Боловсролын тэргүүний ажилтан)

1990-ээд оны Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж, гадаадын олон улс орнуудтай харилцах хүрээгээ тэлснээр хамтран ажилладаг орнуудын хэлийг сурах шаардлага зүй ёсоор танигдсан билээ. Энэ үеэс англи хэлийг сурах хөдөлгөөн өрнөж, энэ хэлийг гадаадын бусад хэлнээс хэт өндөрт тавьж, харин Орос оронтой харилцах харилцааны байдлаас болж орос хэлийг үл тоомсорлох хандлага их дэлгэрсэн байсан боловч сүүлийн жилүүдэд орос хэлний гаршаагүй хэрэгцээ шаардлагыг ойлгож ухамсарлах болсон юм.

Ер нь шинжлэх ухаан техникийн асар их хурдацтай хөгжлийн үе болох шинэ зуунд гадаад хэлийг мэдэхгүйгээр гадаад ертөнцтэй харьцаж, шинэ, шинэ мэдээлэл авах зайлшгүй хэрэгцээ шаардлага амьдралаас урган гарч байна. Одоо их, дээд сургууль төгсөгчдийн гадаад хэлний мэдлэг болон компьютерийн мэдлэг өндөр байх шаардлага нийгмийн захиалга болоод байна.

Гадаад хэл сурах түвшинг 3 хувааж үздэг бөгөөд их, дээд сургуульд хэлний анхан шатны болон дунд шатны түвшингийн мэдлэг эзэмшсэн суралцагсад дээд шатны мэдлэг олгох буюу өөрөөр хэлбэл тухайн эзэмшиж байгаа мэргэжлийн хэл сургах зорилт танигддаг байсан. Энэ зорилтын дагуу гадаад хэлний багш нарын өмнө оюутныг мэргэжлийн бичгийн хэлэнд сургах, урьд эзэмшсэн дүрмийн мэдлэгийг нь гүнзгийрүүлэн судлуулах үндсэн дээр мэргэжлийн ном зохиол гадаад хэл дээр ашиглаж чаддаг болгож сургах зорилго танигддаг. Ийм нөхцөлд багш нар өмнөө тавьсан зорилгод хүрч чадаагүй байна. Гэтэл одоо элсэгчдээ авсан судалгаанаас үзэхэд 24,9 хувь нь англи хэлний анхан шатны мэдлэгтэй, 75,1 хувь нь орос хэлний анхан болон дунд шатны мэдлэгтэй ирж байгаа бөгөөд англи хэл үзсэн элсэгчид нь орос хэл огт мэдэхгүй, нөгөө хэсэг нь англи хэлийг огт мэдэхгүй байгаа байдал нь багш нарт маш их хүндрэл учруулж байна. Ийм тохиолдолд зөвхөн 10 жилд үзсэн хэлийг иашаа нь үргэлжлүүлэн заана гэжээр нөгөө хэлийг нь бас заах шаардлага нийгмийн захиалга болон гарч ирэдэг. Нэгэнт гадаад хэлний анхан болон дунд шатны мэдлэгийн эрс алгаатай 2 түвшинтэй оюутнуудад гадаад хэл заахад багш нараас уйгагүй ажиллах нөр их хөдөлмөр шаардагддаг.

Энэ 2 түвшинг аль болох богино хугацаанд ойртуулж, цаашид нэг түвшинд хүргэж мэргэжлийн үг хэллэгтэй, дүрмийн цэгцтэй мэдлэгтэй болгох хэрэгтэй болдог. Одоогоор хүрээд байгаа түвшин гэнэх:

1. Оюутнуудад хэл заагааг хийж, зөв унших даллага хийлгэж, уншиж сургаж байна.
2. Мэргэжлийн тодорхой тооны үг хэллэгтэй, тухайлбал мэргэжлийн ном зохиол ашиглаж чаддаг чадвар суулгаж шаардагдах тооны мэргэжлийн үгийн баялагтай болгодог.
3. Уншсан материалын товчлол, аннотаци бичих, толоогоо гаргах гэх мэт ашигласан материалла баяж нэгтгэх далал чадвар суулгаж байна.

4. Дүрмийн тодорхой хэмжээний мэдлэг эзэмшүүрж байна. Гэвч сургалт мавнь 2 талтай үйл ажиллагаа учир нөгөө талын буюу оюутны идэвхгүй байдлаас сургалтын үр дүнд сөрөөр нөлөөлж байгаа хүчин зүйлүүд бас байна. Үүнд:

1. 1998 оноос хойшхи арван жилийн сургууль төгсөгчид сурах наад захын арга барил эзэмшээгүй, арван жилийн ерөнхий суурь мэдлэг асар доогуур, бие хүний хувьд ч төлөвшөөгүй байгаа нь анги алгассантай холбоотой байна гэсэн дүгнэлтэнд хүргэдэг.
2. Гадаад хэл нь мэргэжлийн гол хичээл биш гэсэн хандлагаас болж хэлний хоёрдугаар зэрэгт тавих дутагдал нийтэд хамттай байдаг.
3. Арван жилд судлавал зөвхөн түвшингийн хэлний суурь мэдлэггүй учир хэл үзэх явцад тулгарсан бэрхшээлээс шантах, үүнээс болж хэлээр хичээллэхгүй ор тас хаях үзэгдэл ч гардаг.
4. Практикаас харахад арван жилд орос хэл судалсан оюутнууд аль аль хэлэнд хурдан сурч, харин англи хэл судалсан оюутнууд нь 2 хэлний аль алинд нь таруу байна. Энэ нь орос хэлний заах сургалтын уламжлал тогтсон, материаллаг бааз, багшлах боловсон хүчин сайн бэлтгэгдсэнтэй холбоотой болов уу гэж бодож байна.
5. Гол дутагдал гэвэл дүрмийн мэдлэг шаардлагын түвшинд хүрэхгүй, дүрэм судлахаас халтаж зайлсхийх нь ихэнх оюутнуудын хувьд хамттайрсан дутагдал байдаг. Хэрэв оюутнууд дүрмэнд анхаарч дэдлага сайн хийх юм бол энэ дутагдлыг арилгах боломжтой гэж үзэж байна.
6. Англи, орос хэлний зэрэг үзэж байгаа нь оюутны хувьд ачлалал ихсэх бэрхшээл тулгарч байсан.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэлт хийн шашинд анхаарч ажиллах зүйл байна. Үүнд:

Хэлний бус орчинд гадаад хэл сурахад анхаарах ёстой зүйл бол ярианы дэдлага олгох явдал юм. Тгээд ч ярианы дэдлага олгох хүрэлцээгүй цаг хичээлийн хөтөлбөрт байхгүй учир ахлах даамжаанд хэлнийг гүнзгийрүүлэн судалж ярианы дэдлага олгох дугуйлан хичээллүүлэх шаардлагатай.

Гадаад хэлний багш нар тогтмол мэргэжил дээшлүүлэх шаардлагатай тул багшийн мэргэжил дээшлүүлэхэд онцгой анхаарах цаг болжээ.

Хэлний өндөр түвшингийн мэдлэгтэй цөөн тооны оюутнуудыг тусгай хөтөлбөрөөр хичээллүүлж эрх зүйч мэргэжлийн зэрэгцээгээр "эрх зүйч-орчуулагч" үнэмлэх олгож болох юм.

Гадаад хэлний хичээл дээр зөвхөн багшийн яриа, ярианы темпэд дасаж өөр темптэй яриа мэдээллийг хүлээж авч чадахгүй болдог байдал тарлаг тул техник хэрэгсэлээр өргөн хангаж, хэлний лаборатори байгуулах шаардлагатай

байна.

Хоёр хэлийг цувруулж үзвэл оюутнуудын ачаалал багасч тухайн судалж буй хэлэндээ илүү шамдан суралцах боломж гарах юм.

Сүүлийн 2 жилийн дүнгийн судалгаанаас авч үзэхэд гурав буюу түүнээс дээш шалгалтанд хангалтгүй дүн үзүүлсэн 253 оюутны 77 нь буюу 30,4 хувь аль нэг хэлний шалгалтанд унасан байна. Нэгдүгээр дамжааны оюутнуудаас санал асуулга авч үзэхэд оюутнууд 2 хэлийг цувруулж үзэх нь зүйтэй гэсэн саналыг 100 хувь дэмжжээ байна. Аль хэлийг нь эхэлж үзэх шаардлагатай вэ? гэсэн асуултанд 95 хувь нь орос хэлийг эхэлж үзье гэжээ. Учир нь мэргэжлийн ном, зохиолыг орос хэл дээр ашиглаж, семинарт бэлтгэх, ажигбар, ангийн ажил бичихэд орос хэл дээр байгаа ном, сурах бичиг ашиглах гэрцаагүй шаардлагатай байдаг тул эхэлж орос хэл үзсэн нь дээр гэж санал гаргажээ. Иймээс олонхийн саналар 2001-2002 оны хичээлийн жилээс орос хэлийг нэгдүгээр дамжаанд, англи хэлийг хоёрдугаар дамжаанд үзэж эхэлтээ.

Бидний үзэж байгаагаар дээрхи тохиолдолд гадаад хэлний сургалтын чанарыг сайжруулж болно гэж үзэж байна.



## **"ШИХИХУТУГ"**

*Монголын Зохиолчдын Эвлэлийн шагналт,  
1989, 1999 оны "Балор цол"-ын эзэн Яруу найрагч*

*Ц.Чамддорж*

*/Монголын төр, хууль цаазны үзэмж  
гарамгай зүтгэлтэн ШИХИХУТУГТ сөгдмү/*

Төрийн их заргачийн тонгорог мэтү харцана  
Төмөр илд ч хута үсрэм  
Үнэний голоор зэйтэж, үгийн шярэлдээ заазахал  
нь  
Үндэс хэрсэн газар чулуугаа тослом.  
Ус дагасан мод ч үгэнд нь ором ШИХИХУТУГ  
Мод дагасан ус ч үгэнд нь ором ШИХИХУТУГ  
Хөх танхим дотроо  
Хөмсөг хөдөлгөн хөлхөж  
Хөвсийг зуухлаа зууж  
Хөх нээдээ хазаж  
Хэргийг номөргөж  
Хэнгэрэгийг дэлдүүлж  
Шилдэн дарахаа дараж  
Ширвээ сахлаараа уруул эсгэж  
Шихихутугийг цааз сонгоход  
Зүрх шярхийж  
Шингэж байсан нар  
Сар мөргөн, тэнгэрийн заадас дээгүүр  
Харайсан,  
Цангасан газар үнэнийг залгилж  
Цацхдаан буруут ирлэж, өөрийгөө шавчсан  
Тэнгэрийн хөх гэрэгэ дор  
Газрын хэрэг залрахал  
Сар хээр хонож  
Нар төөрсөн.  
Загал моринь зүсийг  
Загал хэвээр нь шүүсэн  
Засаг их цаазыг  
Зайгүй дагаж шүүсэн  
Хөх илдээр бус хөх үгээр шүүсэн  
Мориньхоо гэлдэрэнд болож шүүсэн  
Монгол толгойгоор шүүсэн  
Үүлтэй шангирсан үг бүхний нь  
Өргөс хүртэл тонгойж сонссон  
"ИХ ЗАСАГ"-ийг бүтээсэн ч  
Санаа арилсангүй явж,  
Эртний мэргэдийн өмнө  
Ухаан хоёргүй явж,  
Өөрийгөө хүртэл шүүж,  
Өөрийнхөөрөө явсан  
Өдөр шиг саруулхан ШИХИХУТУГИЙН

Өндөр их үгэнд  
Өглөө бүхэн ортугай  
Үдэш бүхэнд ортугай  
Тэнгэр шиг үзэний  
Наран талд нь явсан ШИХИХУТУГ  
Тэмэжний хажууд  
Сүүдэр шиг нь явсан ШИХИХУТУГ  
Үхэх төрөхийн алаг завагт  
Үзэний өмнө алдаж гэмхэнэ  
Өөрийгөө ч цахлал зоригтой  
Өрлөг их ШИХИХУТУГ

**ТЭМЦЭГЭЭ**

**Эрхлэн гаргасан  
"ШИХИХУТУГ"  
ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ**

**СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИ**

**Ерөнхий редактор**

**Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН**

**Редакцийн гишүүд**

**Галдангийн СОВД  
Жигжээдийн БОЛДБААТАР  
Чимэдийн ЭНХБААТАР  
Жамсрангийн БЯМБАДОРЖ  
Жаргалантын ЭЛБЭГСАЙХАН  
Бирваагийн МАНДАХБИЛЭГ  
Түдэвэрчэнгийн БАЯРМАА**

**Нарийн бичгийн дарга**

**Чингэл-Очирын БАЯРТУУЛ**

**Хаяг:**

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Соёлын гудамж,

"Шихихутуг" ХЗДС-ийн байр.

Утас: 323392, 320176

Факс: 976-11-323392

Жилд 4 дугаар хэвлэгдэн гарна.

Угсын бүртгэлийн дугаар 173

**"Мөнхийн үсэг"  
хэвлэх үйлдвэрт хэвлэв.**